

## ГАРЧИГ

<b>1. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:.....</b>	<b>4</b>
1.1. Ерөнхий мэдээлэл.....	4
1.2. Төслийн байршил.....	5
1.3. 2022 оны Уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга.....	6
<b>2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....</b>	<b>9</b>
2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	
<b>3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ.....</b>	<b>13</b>
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	13
<b>4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</b>	<b>17</b>
<b>5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</b>	<b>22</b>
<b>6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРАГ ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</b>	<b>22</b>
<b>7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ:.....</b>	<b>23</b>
<b>8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..</b>	<b>23</b>
<b>9. ХОГ, ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</b>	<b>27</b>
<b>10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....</b>	<b>31</b>
<b>11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</b>	<b>36</b>
<b>12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧИДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</b>	<b>37</b>
<b>13. “ТЭР БУМ МОД” ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД МОД ТАРИХ.....</b>	<b>39</b>
<b>14. ДҮГНЭЛТ.....</b>	<b>40</b>

## ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт 1.Төслийн талбайн булангийн цэгүүд.....	5
Хүснэгт 2. 2022 онд олборлот хийсэн блокуудын дугаар болон талбайн хэмжээ.....	7
Хүснэгт 3. 2022 онд техникийн нөхөн сэргээлт болон шимт хөрсөөр хучилт хийсэн талбайн хэмжээ..	8
Хүснэгт 4. 2022 онд Биологын нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ.....	8
Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....	14
Хүснэгт 6. Төслийн талбайн техникийн нөхөн сэргээлтийн биелэлт .....	21
Хүснэгт 7: 2022 онд Дүйцүүлэн хамгааллын ажил хийгдсэн талбайн байрил болон нэршил.....	22
Хүснэгт 8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	26
Хүснэгт 9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .....	30
Хүснэгт 10. орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд авсан хөрс болон усны дээж авсан цэгийн байршил .....	31
Хүснэгт 11. Хөндлөнгийн хяналтын хүрээнд авсан хөрс болон усны дээж авсан цэгийн байршил ын цэгийн байршил .....	32
Хүснэгт12. орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн нийт ажил болон хяналтын цэгийн байршил .....	35

## ЗУРАГНУУД

Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг:.....	5
Зураг 2. Завхан аймгийн уул зүй:.....	9
Зураг 3. Завхан аймгийн усны ай сав:.....	11
Зураг-4:Дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал .....	17
Зураг-5: В-1-с В-8 блокуудад техникийн нөхөн сэргээлт хийсний дараа шимт хөрсний хучилт хийх явц .....	18
Зураг-6: В-1-с В-10 блокуудад техникийн нөхөн сэргээлт хийж шимт хөрсний хучилт хийсний дараах харагдах байдал .....	18
Зураг-7: Шимт хөрсийг хуулсан В-20, С-24 блокуудын харагдах байдал .....	19
Зураг-8: 2022 оны биологын нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд үр тарьж буй явц.....	20
Зураг-9: 2022 оны биологын нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд үр тарьсан талбайг услаж буй явц 20	
Зураг-10: Уурхайн нийт ажилагсад ажлын байрны онцлогт нийцсэн сургалтын үед.....	24
Зураг-11: Уурхайн кэмп дээрхи гэрүүд хооронд болон засварын талбайд байрлуулсан галын булан .24	
Зураг-12: Уурхайн кетп болон карьерлуу орох замд байрлуулсан анхааруулах тэмдэглэгээ .....	25
Зураг-13: Уурхайн ахуйн хог хаягдалыг ангилан ялгаж байсан хадгалж байсан зураг .....	27
Зураг-14: Ургамал сумын тамгын газартай хийсэн гэрээний дагуу сумын хогны машинаар ахуйн хог хаягдалаа тээвэрлүүлэх үеийн зураг .....	28
Зураг-15: 2022 онд уурхайн үйл ажиллагааны улмаас үүссэн аюултай хог хаягдалыг хадгалсан байдал .....	29
Зураг-16: орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрснөөс дээж авч буй байдал .....	33
Зураг-17: Хөндлөнгийн хяналтын хүрээнд хөрснөөс дээж авч буй байдал .....	34
Зураг-18: Тосгуур багийн иргэд нийтийн хуралд оролцох үеийн зураг .....	37
Зураг-19: Тосгуур багийн иргэдийн төлөөлөл талбайтай танилцсан байдал болон нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээн авах комисс ажиллах үеийн зураг .....	38
Зураг-20: Завхан аймгийн төв Улиастай сумын төвд хийгдсэн цэцэрлэгт хүрээлэнг хүлээлгэн өгөх үеийн зураг .....	39

## ХАВСРАЛТУУД

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны бүрдэл хэсгүүд тус бүр дээр хэмжилт, дээжлэлт хийж буй агшныг баталгаажуулсан, төсөл хэрэгжиж буй орчны фонтой хамт авсан гэрэл зураг
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийсэн хээрийн хэмжилт, авсан дээжнүүдийн лабораторийн шинжилгээний үр дүн
- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийг баталгаажуулсан гэрэл зураг
- Нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийг харуулсан гэрэл зураг
- Аюултай хог хаягдлыг устгах, хадгалах арга хэмжээг хэрхэн гүйцэтгэснийг нотлох гэрэл зураг, Гэрээнүүд
- 2022 оны Биологийн олон янз байдлыг илрүүлэх судалгааны тайлан
- Байгаль орчны аудитын ажил гүйцэтгэх гэрээ
- Эрх бүхий байгууллагуудаас гүйцэтгэсэн ажлыг нь хүлээж авсан актын хуулбар
- БОХ-3 маягт. Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн жилийн мэдээ
- Тэрбум мод тарих ажлын хүрээнд хийгдсэн цэцэрлэгт хүрээлэнг хүлээлгэн өгсөн акт
- Хайгуулын ажил, ТЭЗҮ-г хүлээн авсан тушаал, тэмдэглэл
- БОМТ-ний биелэлтийн тайлан хүлээн авах хяналтын хуудас
- Нөөц ашигласны төлбөр тушаасан баримтын хуулбар
- Компаний гэрчилгээ
- Лицензийн хуулбар

## 1. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Ерөнхий мэдээлэл

- Төслийн нэр:*
- “Зүүн Цагаан Толгой” Алтны шороон орд ын ил уурхай
- Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр:*
- “Түүчээ Тэрэг” ХХК
    - Улсын бүртгэлийн дугаар: 9011028020
    - Регистрийн дугаар: 2773791
- Аж ахуй нэгжийн албан ёсны хаяг, утас*
- Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, 2-р хороолол, 70 байр 57 тоот
  - 88116280, 89118883
- Төслийн товч танилцуулга, хүчин чадал*
- Зүүн Цагаан Толгой нэртэй MV-021183 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2017 онд хийсэн хайгуулын ажлаар алтны шороон ордын бодитой боломжтой (B+C) зэрэглэлийн нөөцийг шлихээр 112.11 кг, химийн цэврээр 98.66 кг, үүнээс бодитой (B) зэрэглэлийн нөөцийг шлихээр 110.42 кг, шлихээр 97.17 кг, боломжтой (C) зэрэглэлийн нөөцийг шлихээр 1.69 кг, химийн цэврээр 1.49 кг тогтоосон ба нөөцийн блокуудыг дунджаар 638.78 мг/м<sup>3</sup>, хуулах хөрсний дундаж зузааныг 3.47 м-ээр гэж нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.
  - Төсөлд үйлдвэрийн нөөцийг бодохдоо ашиглалтын үеийн хаягдал 0%, бохирдлыг 14%-аар авч тооцсон ба ордыг 4 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд 650.29 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, магадалсан B үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн 199.8 мян.м<sup>3</sup> элс 98,96 кг алт олборлохоор төлөвлөсөн байна. Жилийн хүчин чадал дунджаар 50.0 мян.м<sup>3</sup> бөгөөд хөрс хуулалтын итгэлцүүр 3.25 м<sup>3</sup>/м<sup>3</sup>.



Төслийн зорилго

- Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар ил аргаар ашиглан олборлолт явуулахад оршино.
- 4 жил

Төслийн үргэлжлэх хугацаа

## 1.2. Төслийн байршил


“Зүүн Цагаан толгой” орд нь засаг захиргааны хувиараар Завхан аймгийн Ургамал сумын Тосгуур багын нутагт хамаарах ба Улаанбаатар хотоос баруун хойш 1250 гаруй км, Завхан аймгийн төвөөс БХ 225км, Ургамал сумын төвөөс баруун урагш 27км зайд байр зүйн зургийн М-46-128-Г, М-46-129-В дугаартай хавтгайнуудыг дамнан байрлана.

- Талбайн хэмжээ: 260,49 гектар

Хүснэгт 1.Төслийн талбайн булангийн цэгүүд

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	94	0	10	48	20	10
2	93	59	50	48	20	10
3	93	59	50	48	23	35
4	94	0	10	48	23	35

Зураг 1. Төслийн талбайн байршилын зураг



### **1.3. 2022 оны Уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга**

2022 онд манай компани нь Зүүн Цагаан Толгой алтны шороон ордын ил уурхайн В-1-ээс В-8, В-10 аас В-11, В-19 аас В-20 болон С-21, С-24 гэсэн 14 ш блокуудад олборлолтын ажил явуулж уурхай 265,22 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 102,43 мян.м<sup>3</sup> элс угаан 45,8 кг алт цэврээр олборлохоор уулын ажлын төлөвлөгөөнд тусгасан.

#### ***1.3.1. Бэлтгэл ажил:***

2022 оны уулын ажлын бэлтгэл ажлын хүрээнд ордын В-1-ээс В-8, В-10 аас В-11, В-19 аас В-20 болон С-21, С-24 блокуудын шимт хөрсийг 0,4 м зузаантайгаар ковшоор түрж ил уурхайн зүүн болон баруун хилийг дагуулан 1,5-2,5 м өндөртэй 3-5 м өргөнтэй нуруулдан шимт хөрсний овоолго үүсгэх ажлыг 03 сарын 26-аас эхлэн хийж гүйцэтгэсэн.

#### ***1.3.2. Ашиглалтын систем***

2022 зүүн цагаан толгой ордын хэмжээнд В-1-с В-8, В-10, С-21 гэсэн 10 блокод орборлолтын үйл ажиллагааг 2022 оны 03 сарын 26–с 2022 оны 10 сарын 15-ны хооронд явууллаа. Уулын ажлыг эхлүүлэхдээ ордын дунд хэсгээс В-6 нөөцийн хэсэгшлийн баруун хойд жигүүрээс Экскаватороор 8 м-ийн орлын өргөнтэй нээж ил уурхай үүсгэн хөрсийг гадаад овоолгод байршуулан ажлын талбай үүсгэн нээсэн. Хөрс хуулалтын ажлын доголын өндөр 1.32-3.5 м хүрч байсан ба Уулын ажлын ахилт нь нөөцийн хэсэгшилд хөндлөн баруунаас зүүн чиглэлтэй хөрс хуулалтын ажлыг түвшин бүрд хөндлөн орлоор хийж улмаар элсийг олборлон ул чулуулагт хүргэж дотоод овоолго хийх ажлын талбай гармагц дотоод овоолгод хөрсийг дүүргэж ажиллаж байлаа.

2022 онд олборлолт явуулсан блокуудын хэмжээг хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 2. 2022 онд олборлот хийсэн блокуудын дугаар болон талбайн хэмжээ*

Д.д	Блокын дугаар	Талбайн хэмжээ га	Д.д	Координат		Д.д	Координат	
1	В-1	0.58182	1	573966	5357278	11	573914	5356500
2	В-2	0.76584	2	574014	5357098	12	573898	5356598
3	В-3	0.57337	3	574000	5357001	13	573951	5356700
4	В-4	0.61762	4	574004	5356897	14	573981	5356799
5	В-5	0.82882	5	574044	5356799	15	573899	5357000
6	В-6	1.17342	6	574004	5356700	16	573872	5357097
7	В-7	1.29804	7	573997	5356599	17	573876	5357197
8	В-8	0.21806	8	573932	5356500	18	573949	5357199
9	В-10	0.52209	9	573924	5356451	19	573947	5357231
10	С-21	0.081	10	573910	5356451	20	573952	5357271
11	Нийт	10 блок				21	574022	5357500
		6.7				22	574012	5357410
						23	573967	5357408
						24	573961	5357438
						25	573963	5357460
						26	573948	5357487
						27	573949	5357499

### 1.3.3. Нөхөн сэргээлт

2022 онд ордыг ашиглахдаа уул-техникийн нөхцөлд тохируулан дотоод овоолготой ашиглалтын системийг сонгож ашигласан талбайд хөрсний дотоод овоолго үүсгэснээр техникийн нөхөн сэргээлтийг уулын ажилтай зэрэг явуулах боломж бүрдсэн юм. Дотоод овоолгоор ашигласан талбайн орон зайг дүүргэсний дараагаар ковшоор түрэлт хийж тэгшилж техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн.

Блокыг ашиглаж хаах бүрт биологийн нөхөн сэргээлт хийх бэлтгэл ажлыг хангах зорилгоор үржил шимт хөрсийг техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд 15-20см-ээс багагүй зузаантайгаар тараан байршуулсан.

*Хүснэгт 3. 2022 онд техникийн нөхөн сэргээлт болон шимт хөрсөөр хучилт хийсэн талбайн хэмжээ*

Д.д	Блокын дугаар	Техникийн нөхөн сэргээлт хийж тэгшилсэн талбайн хэмжээ га	Техникийн нөхөн сэргээлт хийж тэгшилсэн хөрсний эзэлхүүн мянган.м3	Шимт хөрсөөр хучсан талбайн хэмжээ га
1	В-1	0.58	18.97	1.14
2	В-2	0.77	27.49	1.41
3	В-3	0.57	23.07	1.42
4	В-4	0.62	21.17	1.52
5	В-5	0.83	28.8	1.51
6	В-6	1.17	34.97	1.53
7	В-7	1.3	38.75	1.52
8	В-8	0.22	8.81	1.41
9	В-9			1.72
10	В-10	0.52	21.32	1.45
11	С-21	0.08	1.46	0.37
12	<b>Нийт</b>	<b>6.7</b>	<b>224.81</b>	<b>15</b>

2022 онд олборлолт хийгдсэн В-1-ээс В-8 болон В-10, С-21 блокуудыг бүрэн гүйцэт шимт хөрсний хучилт хийгдсэн ба мөн 2021 онд олборлолт хийж техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байсан В-9-р блокын талбайд шимт хөрсний хучилтыг хийлээ.

*Хүснэгт 4. 2022 онд Биологын нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ*

Д.д	Блокын дугаар	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ га	Д.д	Координат	Д.д	Координат
<b>1</b>	В-16	0.8	<b>1</b>	574271 5357203	<b>6</b>	574207 5356845
<b>2</b>	В-17	0.84	<b>2</b>	574272 5357122	<b>7</b>	574196 5356876
<b>3</b>	В-18	0.72	<b>3</b>	574237 5357048	<b>8</b>	574118 5356992
<b>4</b>	С-23	0.24	<b>4</b>	574223 5356982	<b>9</b>	574198 5357110
<b>5</b>	<b>Нийт</b>	<b>2.6</b>	<b>5</b>	574238 5356850	<b>10</b>	574206 5357205

2021 онд олборлотын ажил хийгдэж техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байсан В-16-ээс В-18 болон С-23 блокууд бүхий 2,6 га талбайд 2022 оны биологын нөхөн сэргээлтийн ажлийн хүрээнд хошоон, хүцэнги, ерөхөг, судан, өлөнгө гэсэн 5 төрлийн ургамлын үрийг 2022.06.17-д тарьж усалгааний ажлийг 2022.09.15 хүртэл хоёр өнжөөд нэг услаж байлаа.





**Цаг уур:** Ургамал сумын нутаг дэвсгэр нь уур амсгалын хувьд манай орны бүх нутгийн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд өвөл, зун нь богинохон, хавар, намар ни урт, халуун хүйтний хэлбэлзэл их байна.


Хүйтний улирал үргэлжлэх хугацаа богино, 10-р сарын сүүлчээс хүйтэрч эхлэн хамгийн хүйтэн үе нь 12, 1-р сарын дунжаар -32-35С хүрч цас бага ордог учир зөвхөн уулын ар, бэл, ам, хөндийнүүдэд цасан бүрхүүл тогтсон байна. Зун нь богино боловч их халуун өнгөрч дулаан үе 6-8-р сард +32-+35С байдаг. Харин хавар, намрын улиралд уур амьсгал нь тогтворгүй, салхины хүч ихэсч, элсээр шуурдаг.

Жилийн аль ч улиралд баруун хойд зүгийн салхи зонхилж дундаж хурд нь 5-12м/с хүрдэг бөгөөд салхины жилийн ба сарын хэлбэлзэл нь 4,5,9-р саруудад салхилалт хамгийн их, 6-р сарын сүүлчээс 8-р сарын эх хүртэл харьцангуй тогтуун 3-4 м/с хурдтай байна. Хур тунадас харьцангуй бага, жилд унах хур тунадасны хэмжээ дунджаар 100-150мм-ээс хэтрэхгүй. Зарим жил хур тунадсаар гачигдан гандуу байх үе ч тохиолдоно.

**Ус зүй:** Хайгуулын талбай нь гидрогеологийн улирлын хомс тэжээлтэй мужид хамаарагдах бөгөөд усан хангамжын хувьд тааруухан, усны горим нь тогтворгүй, хур тунадас уналтын хэмжээнээс шууд хамаардаг, усан сүлжээ муу хөгжсөн газар юм. Ордын хэмжээнд байнгын урсгалтай гол, горхи, булаг, шанд зэрэг хөрсөн дээрхи ус байхгүй зөвхөн талбайн хойд талаар 27км зайтай Хүнгүйн гол урсдаг.

Хүнгүйн гол нь Хангайн нурууны баруун салбар уулаас эх аван урссаар Айраг нуурт цутгадаг. Түүний урт 250 км, өргөн нь 30-40 м, гүн нь 0.3-0.6 м, урсгалын хурд 1,0м/с орчим байна. Голд ганц нэг гарам байдаг боловч ёроолдоо сул элс, лаатай тул машин гатлахад бэрх бөгөөд ус нь элсний хольцтой урсдаг боловч ундны хэрэгцээг бүрэн хангадаг. Голын орчим дахь тэвш хэлбэрийн өргөн хөндий, хуурай сайруудаар бороо хур ихтэй түр зуурын урсагал ус урсдаг.

Зураг 3. Завхан аймгийн усны ай сав



**Ан амьтан:** Энэ нутагт туурайтан амьтдаас хар сүүлт байсан гэдэг боловч сүүлийн жилүүдэд харагдахаа больсон байна. Харин өндөр уулын бүсэндээ цөөн тоогоор аргаль янгир байдаг байна. Махчин амьтдаас чоно, үнэг, хярс амьдрахаас гадна хэвлээр явагч могой, гүрвэл нилээд элбэг үзэгдэнэ.

**Хөрс ургамал:** Хайгуулын талбай нь ботаник-газарзүйн мужлалаар Евроазийн хээрийн мужийн Дагуур Монголын (Төв Азийн) дэд муж дах Говийн умард цөлөрхөг хээрийн мужийн Их нууруудын хотгорын дэд мужид хамаарагдах бөгөөд энд говь хээрийн бүсийн бор өнгийн хайргархаг, дайргархаг элс, элсэрхэг хөрс голлон тархана.

Энэ бүсэд зонхилох бор хөрс нь ялзмагийн зүйл багатай, бага зузаантай (5-10 см орчим) чийг хадгалалт муутай байдаг.

Хонхор газар голын эрэг орчмоор давсархаг хөрс, хужир марз элбэг тархсан бөгөөд энд дэрс ургана. Ургамлын бүрхэвч сийрэг, тачир учир энд тэнд хэсэг хэсгээр ургана. Тайлбай нь ургамлын хувьд ус, чийг бага шаарддаг халуунд тэсвэртэй бутлаг, дэрслэг ургамал зонхилох бөгөөд хазаар өвс, ширх, агь зэрэг хээрийн ургамалын зэрэгцээгээр бор шаваг, хялгана, ортууз, баглуур ургана.

*Дүүргийн дэд бүтэц, эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөв:* Төслийн талбайд хамгийн ойр орших суурин газар нь Завхан аймгийн Ургамал сумын төв бөгөөд зүүн хойш авто замаар 27 км-т байдаг.

Тус сум нь зүүн талаараа Завханмандал, урдуураа Дөрвөлжин, баруун талаараа Увс аймгийн Завхан сумдтай хил залган оршдог ба 349.2 мянган га талбайтай, мал аж ахуй, газар тариалан эрхлэн хөгжүүлж ирсэн ба одоогийн байдлаар 332 өрхтэй, 1214 хүн амтай, 120 мян толгой малтай, үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж 14, төсөвт 6 байгууллага, банкны 2 салбар үйл ажиллагаа явуулж мянгат малчин 20 болж малчин өрхийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж үйлчилгээний салбар хүрээ өргөжин тэлсээр байна.

Төслийн талбайн орчим хүн амын суурьшил харьцангуй сийрэг хэдий боловч суурин газартаа хүн амын суурьшил арай нягт байна. Үндсэн оршин суугчид нь халхууд байх ба нийт иргэдийн ихэнхи нь мал аж ахуй эрхэлж, түүнийхээ ашиг шим, түүхий эдээр амьдрал, ахуйгаа залгуулдаг. Малчид нь таван хошуу малаас бог малыг арай түлхүү үржүүлдэг.

Сумын төвд “МЦХ” ХКомпанийн харьяа холбооны салбар байхаас гадна Мобиком, Юнител, Жи-Мобайл компаниудын үүрэн телефоны үйлчилгээтэй.

Ургамал сумын төвд эмнэлэг, олон тооны жижиг дэлгүүрүүд, 9 жилийн дунд сургууль, хүүхдийн цэцэрлэг, цахилгаан холбоо, ШТС зэрэг үйлчилгээний байгууллагуудтай.

Зам харилцааны хувьд Улаанбаатар-Улиастай-Ургамалын чиглэлийн II зэрэглэлийн замтай бөгөөд өөр бусад аймгийн төв, сумдын төвтэй холбогдсон шороон замуудтай.

Мөн хайгуулын ажил явуулхад жилийн аль ч улиралд хаагуур ч явахад боломжтой жижиг замуудтай.



### **3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

#### **3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

2022 оны БОМТ-нд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлуудаас доорхи хүснэгтэнд тусгагдсан арга хэмжээнүүдийг 2022 оны ашиглалтын үйл ажиллагааны явцад хэрэгжүүллээ.

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
	Хуурайгаар баяжуулах тоног төхөөрмжийн ажилтнуудад амьсгал хамгаалах нэг удаагын хошуувч зүүлгэж байлаа		ш	2500	600	1500000	Ээлж солих болгонд	
	2022.08.04 өдөр Завхан аймгийн УЦУОШТБОШЛабораториор уурхайн хэмжээнд Орчны нийт тоос, тоосонцор зэрэг үзүүлэлтийг уурхайн Клонк, Уурхайн гадна зам, Олборлолтын хэсэг, Кемп, Баяжуулах гэсэн 5 цэгт тодорхойлуулсан.	Хүрээлэн буй орчин хүний эрүүл мэнд	ш	Орчны хяналт шинжилгээний тайланд бичигдсэн		1 удаа	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.	
	Агаарын чанар, физик бохирдлыг тодорхойлох зорилгоор NO2 / Азотын давхар исэл/, SO2 /Хүхэрлэг хий/ шинжилгээг Завхан аймгийн УЦУОШТБОШЛабораториор 2022.08.04 өдөр уурхайн Клонк, Уурхайн гадна замын хэсэг, Кемп, Олборлолтын хэсэг, Баяжуулах гэсэн 5 цэгт тодорхойлуулсан.		ш	Орчны хяналт шинжилгээний тайланд бичигдсэн		1 удаа	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага.	
<b>Гадаргын ба газрын доорхи усны нөөц</b>	Унд, ахуй болон үйлдвэрт хэрэгдсэн худгын усанд 2 удаагын давтамжтайгаар мөн Баяжуулах нуурын усанд шинжилгээ хийлгэж хариуг тайланд хавсаргалаа	Ундны болон технологийн усан хангамж		Орчны хяналт шинжилгээний тайланд бичигдсэн		2 удаа	MNS 0900:2018	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
3	Хөрсөн бүрхэвч	Ашиглалтын талбайд машин техник зорчих замыг тодорхой болгож онцын шаардлагагүй тохиолдолд олон салаа зам гаргаж хөрс талхагдахаас урьдчилан сэргийлж тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан.	Хөрсөн, ургамлан нөмрөг	ш	Өдөр тутмын ажлын зааварчилгаанд тусган зааварчилгаа өгч байлаа			Тухай бүр	
		Уурхайн кемпээс уурхайн карер хүрэх зам болон авто зогсоол дээр замын чиглэл заасан болон стандарт тэмдгийг байршуулсан.	Хөрсөн, ургамлан нөмрөг	ш	70000	10	700000	1 удаа	Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4597 : 2014
		Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг уурхайн кемп дээр байрлах засварын талбайд авч ирэн засаж байлаа	Хөрсөн, ургамлан нөмрөг	ш	Өдөр тутмын ажлын зааварчилгаанд тусган зааварчилгаа өгч байлаа			Тухай бүр	
		Уурхайн шимт хөрсний хуулалт хийхдээ зузаантайгаар 0,4 м зузаантайгаар ковшоор хуулж, ил уурхайн зүүн баруун хилийг дагуулан 1,5-2,5 м өндөртэй 3-5 м өргөнтэй зонхилох салхины чиглэл дагуу нуруулдан шимт хөрсний овоолго үүсгэсэн ба 2022 оны шимт хөрсний овоолго, 2021 оны шимт хөрсний овоолго, 2022 онд биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай, Хяналтын цэг гэсэн 4 цэгээс дээж авч Чийг, SO4, PH, Ялзмаг, NH4, NO4, P2O5 тодорхойлуулсан.	Ил уурхайн карьер	м3	Орчны хяналт шинжилгээний тайланд бичигдсэн Үйл ажиллагааны зардалд тусгасан			Тухай бүр 1 удаа	MNS 5917:2008
		Хөрсний хүнд металлын зарим элементүүд (Cd, Pb, Hg, Cr, Zn, Cu, Co, Sr)-ийг Кемпийн зогсоол, Нөхөн сэргээсэн талбай, Баяжуулах, Хяналтын цэг, Засварын газар, Хогын цэг, Ахуйн бохирдол гэсэн 7 цэгээс авч тодорхойлохлуулсан ба уурхайн клонк, засварын газар, кемпийн авто зогсоол гэсэн 3 цэгээс дээж авч нефтийн бүтээгдэхүүний шинжилгээг хийлгэж хариуг тайланд хавсаргалаа	Хөрсөн, ургамлан нөмрөг	ш	Орчны хяналт шинжилгээний тайланд бичигдсэн			1 удаа	MNS 5850:2019

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
4	Газрын хэвлий	Олборлолт явагдаж дотоод овоолгоор дүүргэлт хийсэн талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийхдээ анхны байгалийн төрхтэй нь адил хэмжээнд хамгийн боломжиг байдлаар дөхүүлэн стандартын дагуу ковшоор гадаргын тэгшилгээг хийж техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэний дараагаар шимт хөрсний хучилгыг хийж дараа жилийн биологын нөхөн сэргээлт хийхэд бэлэн болголоо.	Ил уурхайн карьер	га	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд бичигдсэн				
5	Ургамлан нөмрөг	Хөрсөөр дамжин ургамлыг бохирдуулж болзошгүй хог хаягдлыг ангилж ялган, аюултай хог хаягдалыг / хүнд машин механизмын ажилласан масло, гидрийн шингэн, тос болон түлшний шүүр / хөрсөнд алдагдахааргүй төмөр боошигид хийж хадгалсан ба ахуйн хог хаягдалыг ангилан ялгаж хуванцар савыг төмөр торонд хадгалсан.	Ургамлан нөмрөг	ш	50000	10	500000	Тухай бүр	
		Уурхайн карер орчимд техник төхөөрөмжийг шатхуунаар цэнэглэх үед машин техникийн шатах тослох материал асгарвал тухай бүрд нь шатах тослох материалтай лэлсийг хаман авч уурхайн кемп дээрг авч ирж тусгай хэсэгт бөөгнүүлж хадгалсан.	Ургамлан нөмрөг	ш	30000	15	450000	Тухай бүр	
6	Амьтны аймаг	Уурхайгаас олборлолт явуулах үед үүсэх карьерийн ирмэгт хамгаалах хөмсөгийг тавьж мал амьтанд унаж үрэгдэхээс сэргийлж ажилсан	Ил уурхайн карьер		Өдөр тутмын ажлын зааварчилгаанд тусган зааварчилгаа өгч байлаа			Тухай бүр	
<b>Нийт</b>					<b>3150000</b>				

#### 4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

##### Техникийн нөхөн сэргээлт:

Дотоод овоолгоор дүүргэлт хийх: 2022 онд ордыг ашиглахдаа уул-техникийн нөхцөлд тохируулан дотоод овоолготой ашиглалтын системийг сонгож ашигласан талбайд хөрсний дотоод овоолго үүсгэснээр техникийн нөхөн сэргээлтийг уулын ажилтай зэрэг явуулах боломж бүрдсэн юм. Дотоод овоолгоор ашигласан талбайн орон зайг дүүргэсэний дараагаар ковшоор түрэлт хийж тэгшилж техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн.



*Зураг-4: Дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал.*

**Шимт хөрсийг түрж тараах:** Ашиглаж дууссан блокуудыг хааж техникийн нөхөн сэргээлт хийж дуусмагч биологийн нөхөн сэргээлт хийх бэлтгэл ажлыг хангах зорилгоор үржил шимт хөрсийг 15-20см-ээс багагүй зузаантайгаар тараан байршуулсан.





*Зураг-5: В-1-с В-8 блокуудад техникийн нөхөн сэргээлт хийсний дараа шимт хөрсний хучилт хийх явц*



*Зураг-6: В-1-с В-10 блокуудад техникийн нөхөн сэргээлт хийж шимт хөрсний хучилт хийсний дараах харагдах байдал*

2022 онд олборлолт хийгдсэн В-1-с В-10 болон С-21 гэсэн 10 блок бүхий 6,7 га талбайг бүрэн гүйцэт олборлож талбайд бүхэлд нь техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн ба нийт 15 га талбайд шимт хөрсний хучилтийг хийж 2023 онд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийхэд бэлэн болголоо.

2022 онд олборлот хийхээр төлөвлөж шимт хөрсийг нь хуулсан боловч олборлотын ажил хийгдээгүй В-11, В-19, В-20, С-24 гэсэн 4 блок бүхий талбайнуудыг 2023 оны уулын ажлын төлөвлөгөөнд оруулж олборлолт хийхээр төвлөсөн тул шимт хөрсийг буцаан хучаагүй байна.



*Зураг-7: Шимт хөрсийг хуулсан В-20, С-24 блокуудын харагдах байдал*

#### **Биологийн нөхөн сэргээлт:**

2021 онд олборлотын ажил хийгдэж техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байсан В-16-ээс В-18 болон С-23 блокууд бүхий 2,6 га талбайд 2022 оны биологийн нөхөн сэргээлтийн ажлийн хүрээнд хошоон, хүцэнги, ерөхөг, судан, өлөнгө гэсэн 5 төрлийн ургамлын үрийг 2022.06.17-д тарьж усалгааний ажлийг 2022.09.15 хүртэл хоёр өнжөөд нэг услаж байлаа.





*Зураг-8: 2022 оны биологын нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд үр тарьж буй явц*



*Зураг-9: 2022 оны биологын нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд үр тарьсан талбайг услаж буй явц*



Хүснэгт 6. Төслийн талбайн техникийн нөхөн сэргээлтийн биелэлт

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Техникийн нөхөн сэргээлт	Дотоод овоолго болон ковшоор түрж тэгшлэх	га	6.7	3000000	20100000	2022 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан олборлотын ажилд хийгдсэн талбайд 2022.03.26-2022.10.15 хооронд	
2	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсийг ковшоор түрж тараах	га	15	600000	9000000	2022 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбайд 2022.09.20-2022.10.20 хооронд	
3	Биологийн нөхөн сэргээлт	Ургамлын үр цацах усалгаа хийх	га	2.6	3500000	9100000	2021 онд олборлолт хийж техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбайд	
4	<b>Нийт</b>					<b>38200000</b>		

## 5. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 онд манай компаний зүгээс орон нутгаас санал авч Ургамал сумын Дааган дэл, Зүүн цагаан толгой уурхайн талбай, Хутаг уул, Цагаанхайрхан, Хөтөл ус, Аргалийн хар гэсэн 6 байршилд Биологийн олон янз байдлыг илрүүлэх судалгааг Отгон-Бор хавцал ТББ-аар хийж гүйцэтгүүллээ. Судалгааны үр дүнд 21 зүйлийн ургамал, 11 зүйл хөхтөн амьтад, 11 зүйлийн шувуу бүртгэсэн ба Хутаг уул, Цагаанхайрхан уулыг сонгон дүйцүүлэн хамгаалалыг хэрэгжүүлэхийг санал болгосон ба ховордлын зэрэг өндөртэй зүйлийг сонгон авч хамгааллын менежментийг хэрэгжүүлэх замаар бусад амьтдыг хамгаалах хамтын менежментийн туршлагыг нэвтрүүлэх нь нэн чухал гэж үзжээ Дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэхээр санал болгож буй газрын гол үнэт зүйлийг бид Янгир ямаа, Нөмрөг тас зэрэг зүйлүүд гэж үзэж хамгааллын менежментийг хэрэгжүүлэхийг санал болгосон байна.

2022 оны Биологийн олон янз байдлыг илрүүлэх судалгааны тайланг хавсаргав.

*Хүснэгт 7: 2022 онд Дүйцүүлэн хамгааллын ажил хийгдсэн талбайн байрлал болон нэршил*

Д.д	Судалгаа хийлгэсэн талбайн нэр	Талбайн координат	
1	Дааган Дэл уул	93 49 36.15	48 26 26.5
2	Хутаг Уул	94 17 40.48	48 23 34.44
3	Цагаан Хайрхан уул	94 20 08.30	48 19 5.34
4	Хөтөл Ус	94 27 14.41	48 16 6.92
5	Аргалын Хар	94 23 1.91	48 7 24.17
6	Зүүн Цагаан Толгой уурхай	93 59 58.8	48 21 34.6

## 6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Уг төслийг хэрэгжүүлэхэд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох үйл ажиллагаа явагдаагүй болно.

#### **7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Төслийн талбайд 2017 оны 05 сарын 10-15 ны хооронд тусгай эрх бүхий МУИС-н ШУС антропологи археологын тэнхэмээр талбайн хэмжээнд бүхэлд нь Археологийн судалгааг хийлгэсэн ба ашиглалтын талбайн хэмжээнд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл болон археологи, палеонтологийн олдвор илрээгүй ба 2022 оны олборлотын үйл ажиллагааны явцад ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл болон археологи, палеонтологийн олдвор гараагүй болно.

#### **8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт**

2022 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний дагуу нийт ажилагсадад ажлын байрны онцлогт нийцсэн дүрэм зааварыг боловсруулж тогтмол сургалтыг зохион байгуулж байсан. Мөн байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах ажиллагсдыг цахилгаан хэрэгсэлтэй харьцаж ажиллах арга ажиллагаанд сургаж, гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулаж байлаа.

Гал унтраах хэрэгсэлийг уурхайн кэмп дээр байх гэрүүд болон бүх техник тоног төхөөрөмжнүүдэд байрлуулах галын буланг зохих газруудад байрлуулах ажлийг хийж гүйцэтгэсэн:



Зураг-10: Уурхайн нийт ажиллагсад ажлын байрны онцлогт нийцсэн сургалтын үед



Зураг-11: Уурхайн кэмп дээрхи гэрүүд хооронд болон засварын талбайд байрлуулсан галын булан





Зураг-12: Уурхайн кетп болон карьерлуу орох замд байрлуулсан анхааруулах тэмдэглэгээ

Хүснэгт 8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Байгалийн давагдашгүй хүчин зүйл	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулж байлаа	Уурхайн нийт ажилчид	1	Уурхайн үйл ажиллагааны зардал		Жилд 1 удаа	
2	Галын аюул гарах	Ажиллагсдыг цахилгаан хэрэгсэлтэй харьцаж ажиллах арга ажиллагаанд сургаж, гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулсан	Уурхайн нийт ажилчид	2	Уурхайн үйл ажиллагааны зардал		Жилд 2 удаа	
3		Гал унграах хэрэгслийг зохих газруудад байрлуулж, байнгын бэлэн байршуулсан	Уурхайн кэмп болон техник тоног төхөөрөмжин болон нефтийн агуулах зэрэг газарт	25	40000	1000000	Жилд 1 удаа	
4	Аваар осол гарах	Уурхайн кэмп болон карьер явах зам дагуу болон орх гарах замыг заасан тэмдэг тэмдэглэгээг байршуулсан	Уурхайн кэмп болон карьерын зам дагуу	15	30000	450000	Жилд 1 удаа	
<b>5</b>	<b>Нийт</b>					<b>1450000</b>		



## 9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

2022 оны хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд уурхайн ахуйн хог хаягдалыг кемп дээр тусгайлан байгуулсан хогийн цэгт ангилан ялгаж хуванцар савыг тусгай төмөр торон саванд цуглуулж бусад хог хаягдалыг тусгайлан ухсан нүхэнд хийж байсан ба дүүрмэгч Ургамал сумын тамгын газартай гэрээ хийж сумын төвийн нэгдсэн хогын цэгт тээвэрлэн асгах ажлийг хийж байлаа. Ургамал сумын тамгын газартай хийсэн хог тээвэрлэх гэрээг хавсаргав.



*Зураг-13: Уурхайн ахуйн хог хаягдалыг ангилан ялгаж байсан хадгалж байсан зураг*



*Зураг-14: Ургамал сумын тамгын газартай хийсэн гэрээний дагуу сумын хогны машинаар ахуйн хог хаягдалаа тээвэрлүүлэх үеийн зураг*

2022 онд Уурхайн нийт техник тоног төхөөрөмжүүдээс гарсан хаягдал тос масло тосолгооны материалыг кемп дээр засварын талбайн хажууд баршуулсан төмөр боошигнуудад савлан хадгалж байгаа ба 2022 онд улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл бүхий Хай Би Ойл ХК-тай хийсэн гэрээний дагуу тээвэрлүүлэн дахин боловсруулалтанд оруулхаар тээвэрлүүлэх ажлийг хийлээ.





*Зураг-15: 2022 онд уурхайн үйл ажиллагааны улмаас үүссэн аюултай хог хаягдалыг хадгалсан байдал*

Хүснэгт 9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлсэн хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Ахуйн	Уурхайн ахуйн хог хаягдалыг кемп дээр тусгайлан байгуулсан хогийн цэгт ангилан ялгаж хуванцар савыг тусгай төмөр торон саванд цуглуулж бусад хог хаягдалыг тусгайлан ухсан нүхэнд хийж байсан ба дүүрмэгч Ургамал сумын тамгын газартай гэрээ хийж сумын төвийн нэгдсэн хогын цэгт тээвэрлэн асгах ажлийг хийлээ.	Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд	ш	265000	3	795000		
2	Үйлдвэрийн								
3	Аюултай	Уурхайд ажиллаж байсан нийт техникүүдын ажилласан тос, тосолгооны материалыг төмөр боошгинд хийж хадгаласан ба улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл бүхий Хай Би Ойл ХК-тай хийсэн гэрээний дагуу боловсруулалтанд оруулхаар тээвэрлэсэн.	Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд	ш	500000	1	500000	Жилд 1 удаа	
	Нийт						1295000		

### 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

2022 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 2022 оны 06 сарын 16 өдөр уурхайн олборлот явуулж байгаа мөн нөхөн сэргээлт хийсэн талбай болон кемпийн хогийн цэг, үйлдвэрлэлийн ус авдаг худгын ойролцоо цэг сонгон 7 ш хөрсний дээж авч хүнд металлын болон био ялзмаг, нефтийн бүтээгдхүүний шинжилгээг Уулаанбаатар хотод үйл ажиллагаа явууладаг Цаг уур, орчны хяналт шинжилгээний газар байгаль орчин, хэмжил зүйн тав лабораторид өгч шинжилгээ хийлгэлээ. Сумын төвд байрлах уурхайн ундны ус авдаг худаг болон уурхайн үйлдвэрлэлийн ус авдаг худаг, баяжуулах нуурын уснаас дээж авч Уулаанбаатар хотод үйл ажиллагаа явууладаг Геологын төв лабораторид өгч шинжилгээ хийлгэлээ.

Мөн 2022 оны 08 сарын 04 өдөр Завхан аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвөөр хөндлөнгийн хяналтийн ажлийг хийлгүүлсэн ба хийгдсэн ажил болон шинжилгээний хариуг тайланд хавсаргав.

*Хүснэгт 10. орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд авсан хөрс болон усны дээж авсан цэгийн байршил*

Д.д	Сорьц дугаар	Сорьцын нэр	Шинжилгээний төрөл
1	Хөрс-1	Хяналтын цэг	Хүнд металл, бусад
2	Хөрс-2	2022 шимт хөрс	Чийг, рН, Ялзмаг, SO <sub>4</sub> , NH <sub>4</sub> , NO <sub>3</sub> , P <sub>2</sub> O <sub>2</sub>
3	Хөрс-3	Уурхайн карер баяжуулалтын хэсэг	Хүнд металл, бусад
4	Хөрс-4	2021 шимт хөрс	Чийг, рН, Ялзмаг, SO <sub>4</sub> , NH <sub>4</sub> , NO <sub>3</sub> , P <sub>2</sub> O <sub>2</sub>
5	Хөрс-5	Авто засварын газар	Нефтийн бүтээгдэхүүн
6	Хөрс-6	Уурхайн кэмп ахуйн хог хаягдал	Хүнд металл, бусад
7	Хөрс-7	Шатахуун түгээх станц	Нефтийн бүтээгдэхүүн
8	Ус-1	Ундны ус, сумын төвийн худаг	MNS 900 2018
9	Ус-2	Уурхайн үйлдвэрлэлийн ус уурхайн	MNS 900 2018
10	Ус-3	Баяжуулах нуурын ус	Хүнд металл, бусад

Хүснэгт 11. Хөндлөнгийн хяналтын хүрээнд авсан хөрс болон усны дээж авсан цэгийн байршил ын цэгийн байршил

Д.д	Сорьцын дугаар	Сорьц авсан газрын нэр	Шинжилгээний төрөл
1	687	Шимт хөрс-2022	Чийг, Ялзмаг, SO <sub>4</sub> , PH, NH <sub>4</sub> , NO <sub>3</sub> , P <sub>2</sub> O <sub>5</sub>
2	688	Шимт хөрс-2021	
3	689	Нөхөн сэргээлт хийсэн талбай	
4	690	Хяналтын цэг	
5	691	Уурхайн клонк	Нефтийн бүтээгдэхүүн
6	692	Уурхайн авто засварын газар	
7	693	Уурхайн кемпийн авто зогсоол	
8	694	Уурхайн клонк	Хүхэрлэг хий / SO <sub>2</sub> / Азотын давхар исэл / NO <sub>2</sub> /
9	695	Уурхайн авто замын дагуу	
10	696	Уурхайн кемп	
11	697	Уурхайн олборлотын хэсэг	
12	698	Уурхайн баяжуулалтын хэсэг	Орчны агаарт нийт тоос
13	694	Уурхайн клонк	
14	695	Уурхайн авто замын дагуу	
15	697	Уурхайн олборлотын хэсэг	Тоосонцор PM <sub>2.5</sub>
16	696	Уурхайн кемп	Тоосонцор PM <sub>10</sub>
17	698	Уурхайн баяжуулалтын хэсэг	Хөрсний хүнд металлын зарим элементүүд (Cd, Pb, Hg, Cr, Zn, Cu, Co, Sr)
18	1	Уурхайн кемпийн авто зогсоол	
19	2	Нөхөн сэргээлт хийсэн талбай	
20	3	Уурхайн баяжуулалтын хэсэг	
21	4	Хяналтын цэг	
22	5	Уурхайн авто засварын газар	
23	6	Уурхайн хогын цэг	
24	7	Уурхайн ахуйн бохирдлын цэг	
25		Ундны ус	Ус ерөнхий хими
26		Үйлдвэрлэлийн ус	Ус ерөнхий хими
27		Ахуйн бохирын ус	Бохир ус
28		Гал тогооны бохир ус	





*Зураг-16: орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрснөөс дээж авч буй байдал*





Зураг-17: Хөндлөнгийн хяналтын хүрээнд хөрснөөс дээж авч буй байдал

Хүснэгт 12. орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хурээнд хийгдсэн нийт ажил болон хяналтын цэгийн байршил

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
<b>Агаар чанар</b>								
1	Орчны нийт тоос, тоосонцор	уурхайн Клонк, Уурхайн гадна зам, Олборлолтын хэсэг, Кемп	Жил бүр	1	15000	55000		
	гаарын чанар, физик бохирдлыг тодорхойлох зорилгоор NO2 / Азотын давхар исэл/, SO2 /Хүхэрлэг хий/ тодорхойлуулсан	Клонк, Уурхайн гадна замын хэсэг, Кемп, Олборлолтын хэсэг, Баяжуулах	Жил бүр	1	9500	74500		MNS 4585:2016
<b>Хөрсөн бүрхэвч</b>								
2	Чийг, SO4, PH, Ялзмаг, NH4, NO4, P2O5 тодорхойлуулсан.	2022 оны шимт хөрсний овоолго, 2021 оны шимт хөрсний овоолго, 2022 онд биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай, Хяналтын цэг	Жил бүр	2	56900	341400		
	Нефтийн бүтээгдэхүүнт одорхойлуулсан	уурхайн клонк, засварын газар, кемпийн авто зогсоол	Жил бүр	2	50000	250000		
	Хөрсний хүнд металлын зарим элементүүд (Cd, Pb, Hg, Cr, Zn, Cu, Co, Sr)-ийг тодорхойлуулсан	Кемпийн зогсоол, Нөхөн сэргээсэн талбай, Баяжуулах, Хяналтын цэг, Засварын газар, Хогын цэг, Ахуйн бохирдол	Жил бүр	2	46000	506000		MNS 5850:2019
<b>Усны чанар</b>								
3	Усны чанарын үндсэн үзүүлэлт болон анион, катион, хүнд металл тодорхойлуулсан	Унд, ахуйн хэрэглээний худгаас -1 цэг Уурхайн үйлдвэрлэлийн ус ашиглах худгаас-1 цэг Баяжуулах нуурын ус	Жил бүр	2	50000	250000		MNS 0900:2018
	Бохир усны үзүүлэлтүүд тодорхойлуулсан	Ахуйн бохир ус Гал тогооны бохир ус	Жил бүр	1	58500	117000		
4	Нийт					<b>1593900</b>		

**11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд дараахи ажлуудыг зохион багуулж ажиллаа.

1. Орон нутгаас тавьсан хүсэлтийн дагуу сумын төвын нэгдсэн хогын цэгийг түрж тэгшлэх ажлыг хог хаягдлын төлөвлөгөөтэй уялдуулан хийж гүйцэтгэлээ.
2. Уурхайн үйл ажиллагааны явцад дотоод хяналт шалгалтын түр журам баталж дотоод хяналт шалгалтын түр ажлын хэсэг байгуулж БОМТ-д тусгагдсан ажлуудын гүйцэтгэлийг хянаж доголдолыг засуулах ажлыг зохион байгууллаа.
3. 2022 онд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 101 болон БО-ны ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх заалтын дагуу тусгай эрх бүхий “Алтан Шанага” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн ба аудитын тайлан гармагц хүргүүлхээр төлөвлөөд байна. Ажил гүйцэтгэх гэрээг хавсаргав.
4. Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулсан



**12. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт**

2022 оны 04 сарын 29 ны өдөр Тосгуур багийн Иргэд нийтийн хуралдаан болж компаний зүгээс тухайн хуралд оролцож 2022 оны үйл ажиллагааны талаар багийн иргэд болон сумын удирдлагуудад танилцууллаа.

Тосгуур багийн иргэдийн төлөөлөл 2022 оны 08 сарын 04 ны өдөр уурхайн ашиглалт хийж буй талбай дээр ирж газар дээр нь үйл ажиллагаатай танилцсан.

2022 оны ашиглалтын үйл ажиллагаа дууссантай холбогдуулж 2022 оны 10 сарын 24 өдөр сумын орлогч дарга, газрын даамал, тосгуур багийн засаг дарга болон багийн иргэдийн төлөөлөл оролцсон ажлын хэсэг олборлолт явуулсан талбайтай танилцаж техникийн болон биологын нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээн авлаа.



*Зураг-18: Тосгуур багийн иргэд нийтийн хуралд оролцох үеийн зураг*



*Зураг-19: Тосгуур багийн иргэдийн төлөөлөл талбайтай танилцсан байдал болон нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээн авах комисс ажиллах үеийн зураг*

### 13. “ТЭР БУМ МОД” ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД МОД ТАРИХ

2022 онд “Тэрбум Мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд манай компаний зүгээс Завхан аймгийн төв Улиастай сумын төвд голын ай сав орчимд ойн төгөл байгуулах ажлыг “Шувуун Хар Уул” ХХК-тай хамтран тусгай эрх бүхий байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлсэн ба 4 га талбайг хайсжуулж тохижуулсан ба 6000 ш модны суулгацыг суулгаж аймгын засаг дарга болон Улиастай сумын байгаль орчны улсын байцаагчид хүлээлгэн өгөх ажлыг гүйцэтгэлээ. Хүлээлцсэн актыг хавсаргав.



*Зураг-20: Завхан аймгийн төв Улиастай сумын төвд хийгдсэн цэцэрлэгт хүрээлэнг хүлээлгэн өгөх үеийн зураг*



#### 14. ДҮГНЭЛТ

Энэ онд манай компан нь Зүүн цагаан толгой ордыг ил уурхайн олборлотийн болон хуурайгаар баяжуулах ажлийг 2022 оны 03 сарын 16-ээс 10 сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэлээ. Уурхай олборлот болон баяжуулалтын ажил дууссаны дараагаар нийт олборлолт хийгдсэн 6,7 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлийг хийж гүйцэтгэсэн ба 15 га талбайд шимт хөрсний хучилт хийж 2021 онд олборлолт хийж шимт хөрсөөр хучсан 2,6 га талбайд биологын нөхөн сэргээлтийн ажлийг хийж гүйцэтгэсэн ба энэ онд хийгдсэн 2,6 га талбай болон 2022 онд шит хөрсний хучилт хийгдсэн 15 га талбайд 2023 биологийн нөхөн сэргээлтийн ажлийг хийхээр төлөвлөөд байна.

Олборлолтын ажил явагдаж байх хугацаанд сум орон нутгын удирдлага болон багийн иргэдэд ажлын явцын талаар тодорхой мэдээллүүдийг цаг тухай бүрд нь өгч байсан.

Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд Сум болон Тосгуур багийн иргэдийн төлөөлөлтэй хамтын ажиллагааны гэрээг байгуулж ажиллаа.



## ХАВСРАЛТУУД

**Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны бүрдэл хэсгүүд тус бүр дээр хэмжилт, дээжлэлт хийж буй агшныг баталгаажуулсан, төсөл хэрэгжиж буй орчны фонтой хамт авсан гэрэл зураг**


















## Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийсэн хээрийн хэмжилт, авсан дээжнүүдийн лабораторийн шинжилгээний үр дүн

Маягт 7.8.1

ЦУОШГ-ын Даргын 2020 оны А/54 тоот тушаалын 2-р хавсралт



### УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Завхан аймаг Улиастай хот, Өлзийт баг,  
Өгөөмөр хэсэг, Утас/Факс: 70-46-22-06  
E-mail: zavkhan\_tsaguur@yahoo.com



### ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар: 2022/682

Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газар, хүний нэр хаяг: "Түүчээ тэрэг" ХХК,  
Ургамал сум

Сорьц авсан хүний нэр, албан тушаал: Ц.Сарангэрэл, ахлах техникч

Шинжээчийн код: 02

Сорьцын тодорхойлолт					
Сорьцын нэр	Сорьц авсан он, сар, өдөр	Сорьц хүлээн авсан он, сар, өдөр	Шинжилсэн он, сар, өдөр	Дууссан он, сар, өдөр	Шинжилгээнд ирүүлсэн сорьцын тоо хэмжээ
Худгын ус	2022.08.04	2022.08.04	2022.08.05	2022.08.12	1

Тодорхойлох үзүүлэлт	Хэмжих нэгж	Шинжилгээний аргын стандарт	Шинжилгээний үр дүн	Ерөнхий стандарт MNS 900:2018
Na <sup>+</sup> +K <sup>+</sup>	мг/л	MNSISO 1097:1970 /Н/, CA3 У03:2017	245.0	
Ca <sup>+</sup>	мг/л	MNS ISO 6059:2005	<b>204.4</b>	100.0
Mg <sup>+</sup>	мг/л	MNS ISO 6059:2005	<b>189.7</b>	30.0
NH <sub>4</sub> <sup>+</sup>	мг/л	MNS ISO 7150-1:2006	0.31	1.5
Fe <sup>+</sup>	мг/л	MNS 4430:2005	0.04	0.3
F <sup>-</sup>	мг/л	MNS6272:2011	<b>2.25</b>	0.7-1.5
Cl <sup>-</sup>	мг/л	MNS 4424:2005	<b>759.3</b>	350.0
SO <sub>4</sub> <sup>-</sup>	мг/л	MNS 6271:2011	<b>570.6</b>	500.0
HCO <sub>3</sub> <sup>-</sup>	мг/л	MNS 6832:2020	140.3	
NO <sub>2</sub> <sup>-</sup>	мг/л	MNS 6779:2019	0.003	1.0
NO <sub>3</sub> <sup>-</sup>	мг/л	MNS 6834:2020	1.18	50.0
PO <sub>4</sub> <sup>-</sup>	мг/л	MNS ISO 6878:2001	илр	3.5
ПИЧ	мг/л	MNS 6833:2020	8.7	
Хатуулаг	мг-экв/л	MNS ISO 6059:2005	<b>25.80</b>	7.0
Эрдэсжилт	мг/л	SOPs У 09:2016	2109.3	
Ж/б	мг/л	MNS ISO 11923:2001	1.6	
ЕС	μS/cm	MNS ISO 7888:1999	3900	
Si	мг/л	MNS 6835:2020	4.8	
pH	мг/л	MNS ISO 10523:2008	7.76	6.5-8.5

Тайлбар: илр-илрээгүй. Кальцийн агууламж 2.0 дахин, Магнийн агууламж 6.3 дахин, Фторын агууламж 1.5 дахин, Хлорын агууламж 2.2 дахин, Сульфатын агууламж 1.1 дахин, Хатуулаг агууламж 3.7 дахин их стандартаас давсан байна.


ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН: ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ, ЧМ: /З, БАЛЖИННЯМ/



Хуулбарлан хэрэглэхийг үндэслэн  
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Маягт 7.8.1

ЦУОШГ-ын Даргын 2020 оны А/54 тоот тушаалын 2-р хавсралт



**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ**

Завхан аймаг Улиастай хот, Өлзийт баг,  
Өгөөмөр хэсэг, Утас/Факс:70-46-22-06  
E-mail: zavkhan\_tsaguur@yahoo.com



**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН**

Дугаар: 2022/683

Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газар, хүний нэр хаяг: “Түүчээ тэрэг” ХХК,  
Ургамал сум

Сорьц авсан хүний нэр, албан тушаал: Ц.Сарангэрэл, ахлах техникч

Шинжээчийн код: 02

Сорьцын тодорхойлолт					
Сорьцын нэр	Сорьц авсан он, сар, өдөр	Сорьц хүлээн авсан он, сар, өдөр	Шинжилсэн он, сар, өдөр	Дууссан он, сар, өдөр	Шинжилгээнд ирүүлсэн сорьцын тоо хэмжээ
Ундны ус	2022.08.04	2022.08.04	2022.08.05	2022.08.12	1

